

## ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ШУУРХАЙ АЛБАНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар даатгагч, даатгуулагч, хохирогч, иргэнээс даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, даатгалын тохиолдлыг шуурхай үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиг үүрэг бүхий **жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “даатгал” гэх/-ын шуурхай алба /цаашид “шуурхай алба” гэх/-ны бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.**

1.2. Шуурхай алба нь даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дуудлагын ажилтанг ажиллуулах, даатгалын тохиолдлын газар дээр шуурхай очиж үзлэг хийх, тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг баримтжуулах, даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид нөхөн төлбөрийг үнэн зөв, шуурхай олгох боломжийг бүрдүүлж, **холбогдох мэдээллийг мэдээллийн санд бүрэн нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

### ХОЁР. Шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, тавигдах шаардлага

2.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагчтай хамтран ажиллах гэрээний дагуу шуурхай албаны үүрэг хүлээж ажиллах хуулийн этгээд, эсхүл даатгагч, түүний аймаг, нийслэл дэх салбар нь тухайн орон нутгийн шуурхай албаны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Жолоочийн даатгалын тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан даатгалгүй жолоочийн дуудлагыг жолоочийн даатгалын сангийн шуурхай алба хүлээн авч хэрэгжүүлнэ.

2.2. Шуурхай алба нь даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авах оператор, дуудлагын ажилтан, дуудлагын жолооч, ахлах ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

2.3. **Шуурхай албаны үйл ажиллагаа эрхлэх бүхий л хуулийн этгээд нь энэхүү журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.**

2.4. Шуурхай алба болон түүний ажилтнууд дараах шаардлага, шалгуурыг хангасан байна.  
Үүнд:

2.4.1. Шуурхай алба нь ажлын байртай, даатгалын тохиолдлын дуудлагыг хуанлийн бүх хоногт 24 цагийн турш хүлээн авах байнгын ажиллагаатай утастай, даатгалын тохиолдлыг тодорхойлж, баримтжуулахад шаардлага хангасан техник хэрэгсэл, орон тооны ажилтнуудтай, даатгалын тохиолдлын дуудлагад хүрч ажиллах “Шуурхай алба” гэсэн таних тэмдэг бүхий автомашинтай байна;

2.4.2. Шуурхай албаны ажилтан нь нэр, хувийн дугаар, таних тэмдэг бүхий дүрэмт хувцас, энгэрийн зүүлттэй, даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн тэмдэглэл баталгаажуулах дардастай байна;

2.4.3. **Шуурхай албаны дуудлагын ажилтан нь автомеханикч, инженер эсхүл эрх зүйч мэргэжилтэй байна;**

2.4.4. Шуурхай албаны нийт ажилтнууд Албан журмын даатгагчдын холбоо /цаашид “холбоо” гэх/-оос баталсан хөтөлбөрийн дагуу анхан шатны болон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, хохирол үнэлэх чадвар эзэмшсэн байна.

2.5. **Холбоо нь жолоочийн хариуцлагын даатгалын шуурхай албаны үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.**

### ГУРАВ. Шуурхай албаны автомашины өнгө, бичиглэл, дуудлагын ажилтны нэр бичиглэл

3.1. Шуурхай албаны автомашин нь үндсэн шар өнгөтэй, хөх өнгийн тойрсон судал/кант/-тай байгууллагын лого/эмблем/-той, “ШУУРХАЙ АЛБА” гэсэн бичиглэл, дуудлагын утасны дугаар, шар өнгийн туузан хэлбэртэй анивчдаг гэрэл, ослын газрыг тусгаарлах хэрэгсэл/тумб/-тэй,

дуудлагын ажилтан нь зүүн энгэртээ нэр, ар талдаа “ШУУРХАЙ АЛБА” гэсэн бичиглэл бүхий өмсгөл/хантааз/-тэй байна. /Журмын хавсралт 5-д заасан загвар бүхий/

3.2. Шуурхай албаны автомашин нь #FFFFOO- код бүхий үндсэн шар өнгөтэй, хаалганы шилний доод ирмэгээс доош **150мм** өргөнтэй #OOOOF- код бүхий хөх өнгийн судал/кант/- тай байна.

3.3. Шуурхай албаны автомашин нь урт өргөнөөрөө 350мм бүхий хэмжээтэй байгууллагын лого/эмблем/-г урд талын хоёр хаалганд голлуулж байрлуулна.

3.4. Мөн автомашин нь MNS 4333:96 стандартын дагуу 100х60мм хэмжээт үсэг бүхий “ШУУРХАЙ АЛБА” бичиглэлийг хоёр хажуугийн судал/кант/-ыг голлуулан үндсэн өнгөөр, 90х55мм хэмжээт тоо бүхий дуудлагын утасны дугаарыг хойд талын хоёр хаалганы урд ирмэгээс 50мм, доод ирмэгээс 200мм зайд хөх өнгөөр бичнэ.

3.5. Мөн стандартын дагуу 50х30мм хэмжээт үсэг бүхий “ШУУРХАЙ АЛБА” бичиглэлийг дуудлагын ажилтны хантаазны ар талд захнаас доош 100мм зайд голлуулж, 12х10мм хэмжээт үсэг бүхий овгийн эхний үсэг, нэрийг зүүн энгэрт тод харагдахуйцаар бичнэ.

### **ДӨРӨВ. Даатгалын тохиолдлын тухай мэдээлэл хүлээн авах, бүртгэх**

1.1. Шуурхай албаны ажилтан даатгалын тохиолдлын дуудлагыг хүлээн авч, мэдээлэл өгсөн цаг хугацаа, мэдээлэгчийн овог нэр, хаяг, утасны дугаар, мэдээллийн товч утгыг энэ журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан маягтаар холбооны мэдээллийн санд тухай бүр бүртгэж дугаар авах, дараах зөвлөгөөг дуудлага өгсөн этгээдэд өгч, шаардлагатай арга хэмжээг авна. Үүнд:

1.1.1. Тухайн даатгалын тохиолдолд буруутай этгээд нь тодорхойгүй, холбогдогчийн гэм буруутай нь тогтоогдоогүй нөхцөлд замын цагдаагийн байгууллагад заавал мэдэгдэхийг зөвлөх, мөн өөрөө мэдэгдэх;

1.1.2. Замын цагдаа болон шуурхай алба даатгалын тохиолдлын газар дээр үзлэг хийх тохиолдолд тээврийн хэрэгслийг хөдөлгөхгүй байх, даатгалын тохиолдлын газрыг орхиж явахгүй байхыг анхааруулах;

1.1.3. Даатгалын тохиолдлын газарт шуурхай алба очих боломжгүй, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй үед даатгалын тохиолдолд холбогдсон жолооч нар харилцан тохиролцож гэм бурууг хүлээн зөвшөөрсөн бол даатгалын тохиолдол болсныг нотлох баримт бичиг бүрдүүлэх, **энэ журмын зургадугаар хавсралтаар баталсан маягтын дагуу даатгалын тохиолдлын тодорхойлолтыг бөглөж шуурхай албанд хандан магадлуулах талаар зөвлөгөө өгөх** /фото зураг, гэрчтэй бол түүнээс тодорхойлолт болон хаяг, утсыг нь авах гэх мэт/;

**1.1.4. Даатгалын тохиолдлыг нотлох, мөн нөхөн төлбөр авахад бүрдүүлэх шаардлагатай баримт материалын талаар зөвлөгөө өгөх;**

1.2. Оператор нь даатгалын тохиолдлын мэдээлэл хүлээн авсан даруйд даатгалын тохиолдлын газарт очих дуудлагын ажилтанг хуваарилж нэн даруй явуулна.

1.3. Оператор нь даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан эсхүл зам тээврийн осол гаргагчид хоорондоо маргалдаж байвал замын цагдаад мэдэгдэхийг зөвлөж, өөрөө мэдэгдэнэ.

1.4. Оператор нь дуудлагын ажилтан даатгалын тохиолдлын газар дээр үзлэг хийсний дараа түүнээс үзлэгийн тэмдэглэлийг бүртгэгдсэн дуудлага нэг бүрээр тулган хүлээн авч, үзлэгийн мэдээллийг Холбооны мэдээллийн санд тухай бүр бүртгэж дугаар авна.

### **ТАВ. Даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг**

5.1. Даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгт даатгалын тохиолдол болсон газрын нэр, зам орчны байдал, цаг хугацаа, даатгалын тохиолдол гаргасан болон бусад оролцогч нарыг бүртгэх, даатгалын тохиолдолд холбогдох бусад баримтуудыг баталгаажуулж авах зэрэг үйл ажиллагааг хамааруулна.

5.2. Шуурхай албаны дуудлагын ажилтан даатгалын тохиолдлын газрын байршлыг сайтар тодорхойлж, даатгалын тохиолдлын үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлэн авч, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн ханган даатгалын тохиолдлын газарт **шуурхай** очиж дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

5.2.1. Даатгалын тохиолдлын улмаас хүний биед гэмтэл учирсан бол эмнэлгийн тусламж яаралтай дуудах буюу эмнэлэгт хүргэх арга хэмжээ авах;

5.2.2. Даатгалын тохиолдлын газарт ирмэгц үзлэг хийх үеийн аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн хэсэг газрыг тойруулан хаалт тавих;

5.2.3. Даатгалын тохиолдол гаргасан жолооч, хохирогчийг тодруулах, жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг шалгаж, видео бичлэг болон фото зургаар баримтжуулж авах;

5.2.4. Даатгалын тохиолдлын үед хэн нэгний буруу, зөвийг тодорхойлоход нөхцөл байдал хүндрэлтэй, эргэлзээтэй, маргаантай байх үед ямар нэг дүгнэлт урьдчилж гаргахгүй байх, тэнд байгаа хүмүүстэй эелдэг харилцах;

5.2.5. **Дуудлагын** ажилтан нь энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу ослын газар дээрх үзлэгийн тэмдэглэлийг үйлдэж гарын үсэг зурж, дардас дарж, мөн даатгалын тохиолдол болсон газар дээрх үзлэгийг онцгой шинж тэмдгүүд, нөхцөл байдлыг оролцуулан видео эсхүл фото зургаар олон талаас нь харагдахуйц, тээврийн хэрэгслийн улсын дугаарыг оруулан баримтжуулах;

5.2.6. **Даатгалын тохиолдол мөн эсэхийг тодорхойлох;**

5.2.7. Даатгалын тохиолдол гаргасан этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мансуурсан, бичиг баримтгүй, насанд хүрээгүй бол түүнийг замын цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5.2.8. Даатгалын тохиолдолд **холбогдсон** жолооч нараас нэмэлтээр тайлбар бичүүлж авч болно.

5.3. **Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй үед даатгалын тохиолдолд холбогдсон жолооч нар харилцан тохиролцож гэм бурууг хүлээн зөвшөөрч байгаа тухай даатгагч, жолоочийн даатгалын санд мэдэгдсэн бөгөөд шуурхай алба очиж амжаагүй бол тухайн жолооч нарын бүрдүүлсэн баримтыг хүлээн авч уг тохиолдлыг тодруулан магадлана.**

5.4. Даатгалын тохиолдлын газарт дуудлагаар очиход уг тохиолдолд буруутай жолооч тухайн шуурхай албаны харьяаллын бус байвал холбогдох даатгагч, жолоочийн даатгалын санд мэдэгдэж, үзлэг хийн тэмдэглэл хөтөлж, баримтжуулах ба холбогдох даатгагч, жолоочийн даатгалын санд уг даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн тэмдэглэл болон бусад баримтыг хүлээлгэн өгнө.

### **ЗУРГАА. Даатгалын тохиолдлын баримт бүрдүүлэх, шилжүүлэх**

6.1. **Шуурхай албаны ахлах ажилтан нь оператороос үзлэгийн мэдээлэл, баримтыг хүлээн авч, Холбооны мэдээллийн санд бүртгэж, бүрдэл хангасан дараах баримтыг нөхөн төлбөр олгох этгээдэд хүлээлгэж өгнө. Үүнд:**

6.1.1. Энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу бүрэн гүйцэд бичиж, баталгаажуулсан үзлэгийн тэмдэглэл болон холбогдох материал;

6.1.2. Даатгалын тохиолдлын газар дээрээс батлагаажуулсан видео бичлэг эсхүл фото зураг /видео бичлэг, цахим файлаар байж болно/;

6.1.3. Ахлах ажилтан нь бүрдүүлсэн баримт материалыг аймаг орон нутгаас ажлын 2 хоногт багтаан Улаанбаатар хотод нэн даруй **нөхөн төлбөр олгох этгээдэд** этгээдэд шилжүүлнэ;

6.1.4. Эрх бүхий этгээд даатгалын тохиолдлын газарт хийсэн үзлэгийн тэмдэглэл, холбогдох зураг, видео бичлэг, баримт материалыг хянаж, тодруулах шаардлагатай бол шуурхай албаны ажилтан болон холбогдох этгээдээр нэмэлтээр баримт гаргуулж болно.

### **ДОЛОО. Хэрэгжилт, хяналт, хариуцлага**

7.1. Шуурхай албаны үйл ажиллагааны жилийн тайланг Холбоо нэгтгэн дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

7.2. Холбоо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх саналыг холбогдох баримтын хамт Хороонд хүргүүлнэ. Хорооноос хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**ШУУРХАЙ АЛБАНЫ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ТАЛААРХ  
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

Дугаар: .....  
(МС-аас олгосон)

.....  
(аймаг, хот, дүүрэг)

1	Даатгалын тохиолдол болсон	огноо	
		цаг, минут	
2	Дуудлага хүлээн авсан	огноо	
		цаг, минут	
3	Дуудлага өгсөн хүний	овог, нэр	
		холбоо барих утас	
4	Даатгалын тохиолдол болсон газрын байршил		
5	Даатгалын тохиолдол болсон үеийн анхны аман мэдүүлэг		
6	Даатгалын тохиолдол гаргасан автотээврийн хэрэгслийн	марк, загвар	
		улсын дугаар	
7	Даатгалын тохиолдол болсон газраас хөдөлсөн эсэх	<input type="checkbox"/> үгүй	
		<input type="checkbox"/> тийм	
8	Даатгалын тохиолдол гаргасан жолооч нь албан журмын даатгалтай эсэх	<input type="checkbox"/> үгүй	
		<input type="checkbox"/> тийм 1. _____ (даатгагч) 2. _____ (даатгагч)	
9	Даатгалын тохиолдол болсон газарт очихоор томилогдсон дуудлагын ажилтны нэр		

Тусгай тэмдэглэл:.....  
.....

Дуудлага хүлээн авсан:

Шуурхай албаны оператор: ..... (.....)

(Гарын үсэг)

(Гарын үсгийн тайлал)

## ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ГАЗАР ДЭЭРХ ШУУРХАЙ АЛБАНЫ ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ

дугаар: .....

(МС-аас олгосон)

20 ... оны ...-р сарын ...-ны өдөр

.....

*(аймаг, хот, дүүрэг)*

Шуурхай албаны дуудлагын ажилтан ..... би .....  
 ..... нарыг байлцуулж ..... аймаг, хотын  
 .....сум, баг, дүүрэг, хорооны нутаг.....  
 ..... гудамж, замд гарсан даатгалын тохиолдлын  
 дуудлагыг ... оны ...-р сарын ...-ны өдрийн ... цаг ... минутад хүлээн авч, газар дээрх үзлэгийг 2... оны  
 ...-р сарын ...-ны өдрийн ... цаг ... минутад хийв.

Даатгалын тохиолдолд өртсөн автотээврийн хэрэгслийн тоо: .....

Даатгалын тохиолдлын улмаас гэмтсэн хүний тоо: .....

Даатгалын тохиолдлын улмаас нас барсан хүний тоо: .....


Автотээврийн хэрэгсэл, жолоочийн тухай:

Тодорхойлолт		А тал	Б тал
Автотээврийн хэрэгслийн	марк		
	улсын дугаар		
	өмчлөгч		
Жолоочийн	овог, нэр		
	регистрийн дугаар		
	үнэмлэхийн дугаар		
	хаяг		
	утасны дугаар		
Техникийн байдал			
Осол гарах үеийн	хурд	жолоочийн тодорхойлолт	
		гэрчийн тодорхойлолт	
	зорчигчийн тоо		

Хохирогчийн эрүүл мэндийн байдлыг тодорхой бичих:


Тээврийн хэрэгсэлд учирсан эвдрэлийг бүдүүвч дээр тодорхой тэмдэглэж, бичих

А тал



“А” тал/даатгуулагч/.....

“Б” тал/хохирогч/.....



(1) урд буфер (2) баруун урд крыло (3) баруун урд хаалга (4) баруун хойд хаалга (5) баруун хойд крыло (6) урд капот (7) бүхээгний орой (8) тээшний таг (багаж) (9) хойд буфер (10) зүүн урд крыло (11) зүүн урд хаалга (12) зүүн хойд хаалга (13) зүүн хойд крыло)

(тохирохыг зөвлөх буюу доогуур нь зурах)

Зам, орчны байдал:

Замын төрөл	Замын баргаа	Замын байдал	Замын хэсэг
<input type="checkbox"/> Асфальт <input type="checkbox"/> Бетон <input type="checkbox"/> Сайжруулсан шороон <input type="checkbox"/> Хайрган <input type="checkbox"/> Хөрс	<input type="checkbox"/> Шулуун - тэгш: - уруу - өгсүүр <input type="checkbox"/> Налуу - шулуун: - уруу - өгсүүр <input type="checkbox"/> Тахир - тэгш - уруу - өгсүүр <input type="checkbox"/> Эвдрэлтэй <input type="checkbox"/> Уул, жалга, гол	<input type="checkbox"/> Хуурай <input type="checkbox"/> Нойтон <input type="checkbox"/> Мөстэй <input type="checkbox"/> Цастай <input type="checkbox"/> Хальтиргаатай <input type="checkbox"/> Чийгтэй <input type="checkbox"/> Шавартай	<input type="checkbox"/> Уулзвар дээр: -Зохицуулагддаг -Зохицуулагддаггүй <input type="checkbox"/> Явганы гарцтай <input type="checkbox"/> Автобусны зогсоол бүхий <input type="checkbox"/> Төмөр замын гарамтай <input type="checkbox"/> Гүүр, тунельд <input type="checkbox"/> Талбай <input type="checkbox"/> Суурингийн гаднах <input type="checkbox"/> Хорооллын доторх <input type="checkbox"/> Нийтийн хэрэгцээний биш зам
Замын нөхцөл	Зорчих хэсэх	Цаг агаар	Үзэгдэх орчин
<input type="checkbox"/> Нэг чигийн хөдөлгөөнт <input type="checkbox"/> Эсрэг хөдөлгөөнтэй <input type="checkbox"/> Тусгаарлах зурвастай <input type="checkbox"/> Эгнээний тоо: 1 2 3 4 5 <input type="checkbox"/> Явган хүний замтай <input type="checkbox"/> Явган хүний замгүй <input type="checkbox"/> Хашлагатай <input type="checkbox"/> Хашлагагүй <input type="checkbox"/> Хайстай	<input type="checkbox"/> Гэрэлтүүлэгтэй <input type="checkbox"/> Гэрэлтүүлэггүй	<input type="checkbox"/> Тогтуун <input type="checkbox"/> Бүрхэг <input type="checkbox"/> Бороотой <input type="checkbox"/> Цастай <input type="checkbox"/> Аадар бороотой <input type="checkbox"/> Цасан шуургатай <input type="checkbox"/> Манантай <input type="checkbox"/> Салхитай	<input type="checkbox"/> Чөлөөтэй <input type="checkbox"/> Хязгаарлагдмал <input type="checkbox"/> Хангалтгүй



**МАГАДЛАГАА**

20.. он ... сар ... өдөр

20... оны .... дугаар сарын .... ны өдөр даатгалын тохиолдол болсон

.....газарт  
очиход даатгалын тохиолдол гаргасан ..... улсын дугаартай .....  
маркийн автомашины / мотоцикл, механизм, автобус/ -ны жолооч ..... овогтой  
..... нь согтуурсан /мансуурсан/ шинж тэмдэг “.....” байсан болно.  
/ “**үгүй**” эсвэл “**тийм**”-ийн аль тохирохыг бичих/

**Магадлагаа гаргасан:**

..... шуурхай албаны ажилтан:  
..... овогтой .....  
гарын үсэг .....  
утас: .....

**Байлцсан:**

Хохирогч ..... улсын дугаартай .....  
маркийн автомашин/мотоцикл, механизм, автобус/-ы жолооч  
..... овогтой .....  
гарын үсэг .....  
утас: .....



ДААТГАЛЫН ШУУРХАЙ АЛБАНД  
ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ:

20.. он ... сар ... өдөр

.....  
(аймаг, хот, дүүрэг)

20... оны ..... дугаар сарын ..... ны өдөр ..... аймаг/хот/-ийн .....  
сум/дүүрэг/-ын нутаг дэвсгэрт автомашин /мотоцикл, механизм, автобус/ жолоодож явсан  
..... овогтой ..... миний бие өөрийн буруутай үйл  
ажиллагааны улмаас даатгалын тохиолдол гаргаж бусдын эд хөрөнгө/эрүүл мэнд/-д хохирол  
учруулсан юм.

Би бусдад учруулсан хохирлын нөхөн төлбөрийг ..... даатгал  
/даатгалын сан/-ХХК-аас гаргуулах хүсэлтэй байгаа тул миний хүсэлтийг уг даатгалын компани,  
түүний салбар/даатгалын сан/ -т уламжилж өгнө үү.

**Өргөдөл гаргасан:**

..... улсын дугаартай ..... маркийн  
автомашин /мотоцикл, механизм, автобус/-ы жолооч  
..... овогтой .....

гарын үсэг .....

утас: .....

## ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ШУУРХАЙ АЛБАНЫ АВТОМАШИН, ДУУДЛАГЫН АЖИЛТНЫ ӨМСГӨЛИЙН ЗАГВАР

- Шуурхай албаны автомашины өнгө, таних тэмдэг, дуудлагын ажилтны өмсгөл/хантааз/-ийн загвар.



50x30мм хэмжээс бүхий ШУУРХАЙ АЛБА хантаасны ард талд захнаас доош 100мм зайд голлуулна

12 x 10 мм хэмжээст үсэг бүхий овгийн эхний үсэг, нэрийг зүүн энгэрт тод харагдахуйцаар бичнэ

 -#FFFF00

100 мм x 60 мм хэмжээст үсэг бүхий ШУУРХАЙ АЛБА бичиглэлийг хоёр хажуугийн судал/конт/-ыг голлуулан үндсэн өнгөөр

Хаалганы шилний доод ирмэгээс доош 150мм өргөнтэй #0000FF- код бүхий хөх өнгийн судал /конт/

#FFFF00- бүхий үндсэн шар өнгөтэй



Урт өргөнөөрөө 350 мм бүхий хэмжээстэй байгууллагын лого/эмблем/-г урд талын хоёр хаалганд голлуулна

90 мм x 50 мм хэмжээст тоо бүхий дуудлагын утасны дугаарыг хойд талын хоёр хаалганы урд ирмэгээс 50 мм, доод ирмэгээс 200 мм зайд хөх өнгөөр бичнэ

# Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт

*"Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цуурхай албаны ажиллах журам" зургаадугаар хавсралт*

Энэхүү маягтыг тээврийн хэрэгслийн жолооч бөглөнө. Зам тээврийн ослын нөхцөл байдал, түүнд оролцогчдын талаарх мэдээллийг агуулна.

## 1. Зам тээврийн осол болсон газар:

3. Осолд өртсөн тээврийн хэрэгслийн тоо         

(хот (аймар), дүүрэг (сум), хороо (баг)) замын орчны байрлал

4. Бусад тээврийн хэрэгсэлд учирсан хохирол байгаа эсэх ("А" ба "В"-ээс бусад)  Тийм  Үгүй Бусад хөрөнгөд  Тийм  Үгүй зөвийг тэмдэглэх

## 5. Зам тээврийн ослын талаар даатгалд мэдээлэл өгсөн хүний нэр:-----

## 6. Зам тээврийн ослын гэрч:

(овог, нэр, оршин суух хаяг, холбоо барих утасны дугаар)

## 7. "А" Тээврийн хэрэгслийн мэдээлэл /ТХ/

ТХ-ийн марк, загвар \_\_\_\_\_

ТХ-ийн арлын дугаар (VIN)

ТХ-ийн улсын дугаар

ТХ-ийн гэрчилгээ

Жолооны хүрдний байрлал:  зүүн  баруун

ТХ үйлдвэрлэсэн огноо: -----

ТХ-ийн төрөл:  суудлын  ачааны  автобус  мотоцикл  механизм  толлейбус

ТХ-ийн гүйлт /км/: -----

## 8. Жолоодож явсан хүний мэдээлэл

ТХ-ийн өмчлөгч \_\_\_\_\_ (овог, нэр (хуулийн этгээд бол нэрийг бүрэн бичнэ))

Хаяг \_\_\_\_\_

ТХ-ийн жолооч \_\_\_\_\_ (овог, нэр)

Регистрийн дугаар:

Хүйс:  Эрэгтэй  эмэгтэй

Хаяг \_\_\_\_\_

Утас:

Жолооны үнэмлэх

Ангилал     олгосон огноо

Тээврийн хэрэгслийг  ТХ-ийн өмчлөгч  ТХ-ийг жолоодох жолоодож явсан этгээд  ТХ-ийг жолоодох зөвшөөрөгдсөн жолооч

## 9. Даатгагч

(жолоочийн хариуцлагыг даатгасан даатгагч)

Даатгалын баталгаа

Хүчинтэй хугацаа

ТХ даатгалтай эсэх  Үгүй  Тийм

\* "А" ТХ-ийн жолооч өөрийн ТХ-ийн талаар бөглөнө.

"А"\* ТХ-ийн жолоочийн гарын үсэг \_\_\_\_\_

## "А" 10. Зам тээврийн осол гарсан "В"

шалтгаан (зөвийг чагтлах)

1 Согтуугаар т/х жолоодсон  1

2 Уулзвар гарц нэвтрэх журам  2

3 Эсрэг урсгалд орсон  3

4 Ухрах үйлдэл буруу хийсэн  4

5 Хурд хэтрүүлсэн  5

6 Гэрэл дохио зөрчсөн  6

7 Эгнээ байр буруу эзэлсэн  7

8 гадны гэрэл буруу хэрэглэсэн  8

9 Бүрэн бус т/х жолоодсон  9

10 Эргэх үйлдэл буруу хийсэн  10

11 Хүн ба ачаа тээвэрлэх журам  11

12 Анхаарал болгоомжгүй  12

13 Хоорондын зай тохируулаагүй  13

14 Замын нөхцлөөс  14

15 Зогсоох арга хэмжээ аваагүй  15

16 Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу  16

17 бусад  17

## 11. Зам тээврийн осол гарсан хэлбэр

1 /х т/х-тэй урд талаараа мөргөлдсөн  1

2 /х т/х-тэй ард талаараа мөргөлдсөн  2

3 т/х т/х-тэй хажуу талаараа мөргөлдсөн  3

4 т/х-ээр байшин, барилга байгууламж мөргөсөн  4

5 т/х-ээр замын тэмдэг мөргөсөн  5

6 т/х-ээр тусгаарлах зурвас мөргөсөн  6

7 т/х-ээр гүүр, далан мөргөсөн  7

8 т/х-ээр гэрлийн шон, хашлага мөргөсөн  8

9 онхолдсон  9

10 Явган зорчигч т/х-ийн урдугар явж байхад мөргөсөн  10

11 Явган зорчигч т/х-ийн зэрэгцээ явж байхад мөргөсөн  11

12 Явган зорчигч зам дээр зогсож, ажиллаж байхад мөргөсөн  12

13 бусад  13

## 7. "В" Тээврийн хэрэгслийн мэдээлэл /ТХ/

ТХ-ийн марк, загвар \_\_\_\_\_

ТХ-ийн арлын дугаар (VIN)

ТХ-ийн улсын дугаар

ТХ-ийн гэрчилгээ

Жолооны хүрдний байрлал:  зүүн  баруун

ТХ үйлдвэрлэсэн огноо: -----

ТХ-ийн төрөл:  суудлын  ачааны  автобус  мотоцикл  механизм  бусад

ТХ-ийн гүйлт /км/: -----

## 8. Жолоодож явсан хүний мэдээлэл

ТХ-ийн өмчлөгч \_\_\_\_\_ (овог, нэр (хуулийн этгээд бол нэрийг бүрэн бичнэ))

Хаяг \_\_\_\_\_

ТХ-ийн жолооч \_\_\_\_\_ (овог, нэр)

Регистрийн дугаар:

Хүйс:  Эрэгтэй  эмэгтэй

Хаяг \_\_\_\_\_

Утас:

Жолооны үнэмлэх

Ангилал     олгосон огноо

Тээврийн хэрэгслийг  ТХ-ийн өмчлөгч  ТХ-ийг жолоодох жолоодож явсан этгээд  ТХ-ийг жолоодох зөвшөөрөгдсөн жолооч

## 9. Даатгагч

(жолоочийн хариуцлагыг даатгасан даатгагч)

Даатгалын баталгаа

Хүчинтэй хугацаа

ТХ даатгалтай эсэх  Үгүй  Тийм

\* "В" ТХ-ийн жолооч өөрийн ТХ-ийн талаар бөглөнө.

"В"\* ТХ-ийн жолоочийн гарын үсэг \_\_\_\_\_

**12. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал**

“А”		“В”	
Замын хучилт:			
<input type="checkbox"/>	1	Асф-бет	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	2	Цем-бет	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	3	сайжруулсан	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	4	хөрсөн	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	5	хайрган	5 <input type="checkbox"/>
Замын гадаргуугийн байдал:			
<input type="checkbox"/>	1	хуурай	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	2	нойтон	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	3	цастай	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	4	мөстэй	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	5	эвдрэлтэй	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	6	бохирдсон	6 <input type="checkbox"/>
Замын хэсэг:			
<input type="checkbox"/>	1	уулзвар	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	2	гарц	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	3	Явган хүний гарц	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	4	Автобусны буудал	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	5	Төмөр замын гарам	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	6	гүүр	6 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	7	хонгил	7 <input type="checkbox"/>

“А”		“В”	
Үзэгдэх орчин:			
<input type="checkbox"/>	1	чөлөөтэй	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	2	хязгаарлагдмал	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	3	хангалтгүй	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	4	Зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	5	Зорчих хэсэг гэрэлтүүлэггүй	5 <input type="checkbox"/>
Замын онцлог:			
<input type="checkbox"/>	1	тэгш	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	2	хазгай	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	3	шулуун	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	4	өгсүүр	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	5	уруу	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	6	Огцом эргэлт	6 <input type="checkbox"/>

“А”		“В”	
Замын ангилал:			
<input type="checkbox"/>	1	Ердийн зам	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	2	Хорооллын зам	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	3	Тууш зам	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	4	Хорооллын зам	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	5	Аж ахуйн нэгж байгууллагын доторхи зам	5 <input type="checkbox"/>
Бусад:			
<input type="checkbox"/>	1	Суурингийн замд	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	2	Суурингийн гаднах замд	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	3	өдөр	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/>	4	шөнө	4 <input type="checkbox"/>

**13. Учирсан хохирол**

“А” жолоочид  
Учирсан эд материалын мөнгөн дүн:  
\_\_\_\_\_


Нөхөн төлүүлсэн мөнгөн дүн:  
\_\_\_\_\_

“В” жолоочид  
Учирсан эд материалын мөнгөн дүн:  
\_\_\_\_\_

Нөхөн төлүүлсэн мөнгөн дүн:  
\_\_\_\_\_

1. Замын дүрслэл – гудамжны нэрийг оруулна.
2. "А" ба "В" ТХ-ийн хөдөлгөөний чиглэл.
3. "А" ба "В" ТХ-ийн мөргөлдөх үеийн байрлал.
4. "А" ба "В" ТХ-ийн эцсийн байдал.
5. Замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохио.

**14. Анхны цохилт өгсөн газар**  
Сумаар заах (→)



Гэмтлийн нүдээр харагдах байдал

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

“А”\* ТХ-ийн жолоочийн гарын үсэг

\_\_\_\_\_

**13.Зам тээврийн ослын товч утга:**

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

**15.Зам тээврийн ослын товч утга:**

.....

.....


.....

.....

.....

Хоёр жолооч бүртгэл бөглөнөөс хойш аливаа өөрчлөлт хийхийг хориглоно.

**14. Анхны цохилт өгсөн газар**  
Сумаар заах (→)



Гэмтлийн нүдээр харагдах байдал

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

“В”\* ТХ-ийн жолоочийн гарын үсэг

\_\_\_\_\_

**16. Зам тээврийн осолд 2-оос дээш тооны ТХ оролцсон бол тэдгээр ТХ-ийн талаарх мэдээлэл**

---

(ТХ-ийн марк, загвар; улсын дугаар;

---

даатгагч, даатгалын баталгааны сери, дугаар)

---

---

---

---

---

---

---

---

**17. ТХ-д учирснаас бусад хөрөнгөд учирсан хохирол**

Нэр төрөл \_\_\_\_\_ (гэмтсэн зүйлийн нэр төрөл)

Хэний хөрөнгө болох \_\_\_\_\_ (баримтаар нотлогдвол бөглөнө)

**18. ТХ-ийг хөдөлгөж явуулах боломжтой эсэх?**

Тийм  Үгүй

"Үгүй" бол ТХ хаана байгаа талаар \_\_\_\_\_

---

---

---

**19. Тэмдэглэл:**

---

---

---

---

---

---

---

---

“ \_\_\_\_\_ ” \_\_\_\_\_ 20\_ . \_\_\_\_\_ )  
(бөглөсөн огноо) (гарын үсэг) (Овог, нэр (гарын үсгийн тайлал))

**Зам тээврийн осолд холбогдсон талууд маргаантай тохиолдолд цагдаагийн байгууллагад хандаж асуудлаа шийдвэрлүүлнэ.**